



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
“ДАРХАНЫ ДУЛААНЫ СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 17 өдөр

Дугаар а/12

Дархан

Дулааны эрчим хүчний борлуулалтын  
орлогын бичилт гаргах журам  
батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10, Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3, “ДДС” ТӨХК-ийн хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Дулааны эрчим хүчний борлуулалтын орлогын бичилт гаргах журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалыг 2025 оны 01 дүгээр сарын 20-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тушаал батлагдан гарсантай холбогдуулан “ДДС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2024 оны 10-р сарын 07-ний өдрийн а/84 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Д.БАТЖАРГАЛ

452501044

"ДДС" ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2025.01.17-ны  
өдрийн а/12 тоот тушаалын хавсралт №1



## ДУЛААНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ОРЛОГУУЛАЛТЫН ОРЛОГЫН БИЧИЛТ ГАРГАХ ЖУРАМ

### ЗОРИЛГО:

Дулааны эрчим хүчээр хангагдах хэрэглэгчдийн бүртгэлийг сайжруулах, орлогын бичилтийг үнэн зөв бодитой гаргах, нэхэмжлэх, төлбөр тооцоог цаг хугацаанд нь компанийн дансанд төвлөрүүлэх, гэрээний үзүүлэлт, хэрэгжилтэнд хяналт тавихад оршино.

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. ДЭХ-ээр хангагдах захиалга өгсөн хэрэглэгчийн гэрээг алдаагүй, үнэн зөв бодитой хийх
- 1.2. Гэрээний үзүүлэлтийн өөрчлөлтийг тухай бүр гэрээнд оруулж баталгаажуулсны дараа програмд оруулах /Хэрэглэгчийн нэр, хаяг, ам бүл, халаалтын талбай, эзэлхүүний өөрчлөлт г.м /
- 1.3. Дулааны эрчим хүчний үнэ тарифын өөрчлөлтийг хуулинд заасан хугацаанд хэрэглэгчдэд мэдээлж байх
- 1.4. Дулааны эрчим хүч хэрэглэсэн төлбөрийг батлагдсан тарифийн дагуу үнэн зөв тооцоолж нэхэмжлэх
- 1.5. ХХУ-ны тоолуурын заалтыг сар бүр үнэн зөв авч, мэдээг програмд оруулсан байх
- 1.6. Сар бүрийн дулааны бичилтийг хугацаанд нь гаргаж, нэхэмжлэлийг харилцагч ААНБ, айл өрхийн хэрэглэгчдэд хүргэх, харъяалагдах банкуудад байршуулах
- 1.7. Буруу тооцоолж нэхэмжилсэн бичилт, шивсэн төлбөрийг зохих баримт материалыг үндэслэн залруулга хийж, хэрэглэгчид мэдээлэх
- 1.8. Гэрээний хэрэгжилтийн явцад хэмжүүр тоолуурын болон ДЭХ-ний зүй бус хэрэглээтэй холбоотой зөрчил илрүүлсэн ажилтанд тухайн хэрэглэгчид бичигдэж төлөгдсөн нөхөн төлбөрийн орлогоос "Үйл ажиллагааны бус орлогоос урамшуулал олгох журам" -ыг мөрдөж урамшуулал олгох
- 1.9. Дулааны тоолуурын заалт авах өдрүүд нь амралтын өдрүүдээр таарч байвал заалт авах хугацааг 2-3 хоногоор өөрчлөн авах

## ХОЁР. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН БИЧИЛТ ГАРГАХАД ХИЙГДЭХ АЖЛУУД:

ДЭХ-ний борлуулалтын орлогын бичилтийг хийхдээ доорхи хүснэгтэд заагдсан ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

№	Хийгдэх ажил	Хариуцах эзэн	Хугацаа
1	ДЭХ хэрэглэгчтэй гэрээ байгуулах, гэрээний үзүүлэлтийг хянаж баталгаажуулах, жил бүр сунгалт хийх, хэрэглэгчидтэй гэрээний үзүүлэлтийг хянаж тулгах	СБХ-ийн гэрээний мэргэжилтэн	Тухай бүр
2	Холбогдох албаны ажилтнууд айл өрх, ААНБ-аас тоолуурын заалт авах, эргэлт үзлэг, хяналт хийхдээ дулааны эрчим хүчний зүй бус хэрэглээ байгаа эсэхэд хяналт тавих, илрүүлэх, зөрчлийг арилгуулах ажлыг хэрэгжүүлнэ. (Тоолуур гацаасан, гэрээний үзүүлэлтийн зөрчил, дулааны эрчим хүчний алдагдал, температур өндөр буцаасан г.м)	ТБЗА, СБХ, ДДА, ДТХА, ХяХ	Тухай бүр
3	Орлогын байцаагч нар хэрэглэгчээс төлбөр нэхэмжлэхдээ тоолуургүй айл өрхийн ам бүлийн тоо, халаалтын талбай зэрэг хэрэглэгчийн нэхэмжлэлийн гэрээний үзүүлэлтэд орсон тохиолдолд өөрчлөлтийг гэрээний мэргэжилтэнд мэдэгдэж, шалгуулан, гэрээнд өөрчлөлт оруулна.	СБХ-ийн БАМ /борлуулалтын ахлах мэргэжилтэн/, орлогын байцаагчид, гэрээний мэргэжилтэн	Тухай бүр
4	Айл өрхөд ХХУ-ны тоолуур суурилуулсан мэдээг хэмжүүрийн техникч, дулааны хянах хэмжүүр, автоматикийн засварчид болон шуурхай үйлчилгээний ээлжийн мастерууд нь хэмжүүрийн инженерт өгнө.	ДДА-ны хэмжүүрийн техникч, засварчид болон ДТХА-ны шуурхай үйлчилгээний ээлжийн мастерууд	Тухай бүр
5	Айл өрхөд суурилуулсан ХХУ-ны тоолуурыг лацдан баталгаажуулсан мэдээг хэмжүүрийн техникч, дулааны хянах хэмжүүр, автоматикийн засварчин нар өдөр өдөрт нь хэмжүүрийн инженерт өгч хэмжүүрийн инженер судалгааг нэгтгэн жагсаалтаар гэрээний мэргэжилтэнд өгч гэрээний үзүүлэлтийг өөрчлүүлэх	ДДА-ны хэмжүүрийн инженер	Сар бүрийн 24-28-ны дотор
6	Мөн тухайн сард айл өрхөд шинээр суурилуулсан тоолуурын жагсаалтын хамт тоолуургүй задгай болсон хэрэглэгчдийн судалгааг гэрээний мэргэжилтэнд жагсаалтаар гаргаж өгнө.	ДДА-ны хэмжүүрийн инженер	Сар бүрийн 24-28-нд

7	Зуны их засварын ажлын батлагдсан график, ДЦС-ын 0 зогсолтын талаарх мэдээллийг холбогдох албадын инженерүүд СБХ-ийн бичилтийн нябо, ГБХ-ийн даргад өгнө.	ТБЗА-ны Ахлах инженер, ДДА-ны инженер, ДТХА-ны инженер	График батлагдсан үед
8	Тухайн сард хэрэгцээний халуун ус, халаалт нь хаагдсан, хязгаарлалт хийгдсэн орон сууц, айл өрх, ААНБ-ын нэр, хаяг, хасагдах хоногийн мэдээллийг холбогдох инженер, мэргэжилтнүүд жагсаалтаар гаргаж бичилтийн ня-бод өгнө, жагсаалтыг өгсөн эсэхэд албадын дарга нар хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд бичилтийн нябо шаардаж авна.	ТБЗА, ДТХА, ДДА-дарга, инженерүүд, хэмжүүрийн инженер, ТБЗА-ны ахлах инженер, СБХ-ийн БАМ, гэрээний мэргэжилтэн, бичилтийн нябо	Тухай бүр
9	Тухайн сард өөрчлөлт орсон хэрэглэгчийн мэдээлэл, гэрээний үзүүлэлтийг программд үнэн зөв оруулж мэдээлэлийг бичилтийн нябод өгч бодолтыг хийлгэх ба өөрчлөлт оруулсан тухай тайлан мэдээг сар бүр нэгтгэн архивлана.	СБХ-ийн гэрээний мэргэжилтэн, бичилтийн нябо	Дараа сарын 2-ны дотор
10	Нийтийн зориулалттай орон сууцны байрны болон хувийн орон сууц бүхий ХХУ-ны тоолууртай айл өрхийн заалтыг үнэн зөв авч гар утасны программд шивнэ.	СБХ-ийн орлогын байцаагч нар	Сарын бүрийн 25-29-нд
11	Зөвхөн хэрэгцээний халуун усны тоолууртай нийтийн зориулалттай орон сууцны байрны 1 давхар болон зоорийн давхарт байрлах ААНБ-ын ХХУ-ны тоолуурын заалтыг үнэн зөв авч бичилтийн ня-бод өгнө.	СБХ-ийн орлогын байцаагч нар	Сарын бүрийн 25-29 -нд
12	Хэмжүүрийн техникч, засварчид дулааны тоолууртай хувийн орон сууц болон 1 давхрын ААНБ-ын дулааны тоолуур, халуун усны тоолуурын заалтыг авах бөгөөд хэмжүүрийн инженер заалтыг бодож бичилтийн ня-бод өгөх	ДДА-ны хэмжүүрийн хэсэг	Сарын бүрийн 25-28 дотор
13	ХХУ-ны тоолуурын заалтыг бичилтийн ня-бо сар бүрийн сүүлийн ажлын өдөр дулааны програмаас татаж оруулна. /цахимаар ирсэн заалтууд хамаарна/	СБХ-ийн бичилтийн ня-бо	Сарын бүрийн 30,31-нд
14	Эрчим хүчний тухай хуулийн 32.2.2-т зааснаар "Эрчим хүчний тоолуур, хэмжүүр, тэдгээрийн эд анги, битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн буюу хэвийн ажиллагааг алдагдуулсан" бол эрчим хүчний хэрэглээний зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. Тус хуулийн заалтыг тоолуур тавиулж буй хэрэглэгч бүрт танилцуулж ажиллах	СБХ, ДТХА, ДДА-ны хэмжүүрийн хэсэг	Тухай бүр

15	ХХУ-ны тоолуурын заалтыг 3 сараас дээш хугацаагаар өгөөгүй бол задгайгаар тооцон бичилт хийнэ. Энэ тухай тоолуур тавиулсан айл өрх бүрт зааварчилгаа өгч танилцуулж байх	СБХ-ийн ажилтнууд, ДТХА-ны шуурхай үйлчилгээний ээлжийн мастер ДОС-ууд, ДДА-ны хэмжүүрийн хэсэг	Тухай бүр
16	Сар бүр айл өрхийн ам бүлийн хөдөлгөөний өөрчлөлтийн тайланг гэрээний мэргэжилтэн баталгаажуулан, бичилтийн ня-бо-д гаргаж өгөх ба бичилтэнд эргэж хяналт тавина.	СБХ-ийн гэрээний мэргэжилтэн	Сарын бүрийн 28-29-нд өгөх, дараа сарын 2-3 нд хянах
17	Эрчим хүчний тухай хууль, ДЭХ-ээр хангах ААН-н гэрээний дагуу төлбөрөө хугацаандаа төлөөгүй үндэслэлээр алданги тооцох айл өрх, ААНБ-ийн жагсаалтыг гаргаж, Гүйцэтгэх захирлаар батлуулан, бичилтийн ня-бод өгч нэхэмжлэл гаргуулан, хэрэглэгчдэд хүргэх	СБХ-ийн ГБ-ын хэсгийн дарга, БАМ	Сар бүрийн 3-ны дотор
18	Тухайн сарын хэрэглэгчдийн бичилтийг гэрээний үзүүлэлт болон таслалт, залгалтын жагсаалтын дагуу авлагыг үүсгэх, авлагыг зөв үүсгэсэн эсэх, алдаагүй нэхэмжлэл гарсан эсэхэд хяналт тавьж үнэн зөв алдаагүй нэхэмжлэлийг хүлээлгэн өгөх, хүлээн авах	СБХ-ийн бичилтийн ня-бо, ахлах нябо, гэрээний мэргэжилтнүүд, ГБХ-ийн дарга, БАМ, орлогын байцаагч	Нэхэмжлэх гарах бүрд
19	БАМ хүлээн авсан айл өрхийн нэхэмжлэлийг харъяа банкинд байршуулахдаа урд сарын төлөгдсөн нэхэмжлэлийн цэвэрлэгээг хийлгэсэн байх	СБХ-ийн БАМ	Сар бүрийн 3-5-нд
20	Хариуцсан орон сууцны 1 давхрын болон зоорийн давхрын ААНБ-ийн дулааны нэхэмжлэлийг БАМ-ээс авч хэрэглэгчид хүргэх	СБХ-ийн орлогын байцаагч нар	Сар бүрийн 6-7-нд
21	Дулааны тоолуур, хэрэгцээний халуун ус, нэмэлт усны тоолууртай ААНБ-ийн тоолуурын заалтыг ТБЗА-ны тохируулгын хэсэг авч, нэгтгэн, ДДА-ны хэмжүүрийн инженерт өгөх / Тухайлбал дулааны тоолууртай 380 айлын байрны ААН-үүд/	ТБЗА-ны тохируулгын хэсэг, Тохируулгын инженер	Сар бүрийн 15-17-ны дотор
22	ТБЗА-ны тохируулгын инженерийн өгсөн заалтыг ДДА-ны хэмжүүрийн инженер нэгтгэн бодож СБХ-ийн бичилтийн нябод жагсаалтаар хүлээлгэн өгнө. Тоолуурын заалтыг бодох боломжгүй, заалт буруу авагдсан нөхцөлд холбогдох албаар дахин тоолуурын заалтыг авахуулах, шаардлагатай	ТБЗА-ны тохируулгын инженер, ДДА-ны	Сар бүрийн 17-18-ны дотор